



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/232

Мандалговь

М.Батсайханы ажил хүлээлцэх ажлын
хэсэг байгуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйл, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/243 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3 дугаар хэсгийн 3.7.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлчилгээний албаны даргын үүрэгт ажлыг Э.Эрдэнэжаргалд хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Сүхбаатар (Санхүү, төрийн сангийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

Э.Одончимэг (Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Энхмандал (Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

М.Янжиндолгор (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

Б.Баатардорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Ажил хүлээлцэх ажлыг зохих журмын дагуу 2022 оны 10 дугаар сарын сарын 17-ны өдөр зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Сүхбаатар)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ

4312150563